



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/78/НА-СБА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт хот 2022 он	Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518369 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512127 Цахим хаяг: barchidgunseno@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч



**СҮХБААТАРАЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 40
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ц.ДАЙЧИНБАТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,396,802.00</u>	<u>112,700,719.66</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	531,917.16
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	531,917.16
3121	Төгрөг	00.00	531,917.16
31211	Төрийн сангийн харилцах	00.00	3,917.16
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	528,000.00
33	АВЛАГА	00.00	17,461,800.00
335	Бусад авлага	00.00	17,461,800.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	17,461,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	71,396,802.00	94,707,002.50
351	Түүхий эд материал	45,233,186.00	43,585,098.10
35110	Тусгай зориулалттай материал	27,397,861.00	25,674,371.00
35130	Эм боох материал	17,835,325.00	17,910,727.10
354	Хангамжийн материал	16,908,676.00	17,151,904.40
35410	Бичиг хэргийн материал	1,319,630.00	353,500.00
35420	Аж ахуйн материал	7,098,300.00	5,230,900.00
35460	Хүнсний материал	736.00	35,714.40
35470	Бусад хангамжийн материал	8,490,010.00	11,531,790.00
35600	Мал амьтад	9,254,940.00	33,970,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>239,967,001.18</u>	<u>231,734,373.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	239,967,001.18	231,734,373.56
392	Биет хөрөнгө	226,037,001.18	217,804,373.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	199,317,280.01	199,317,280.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,055,733.04	-31,583,599.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,989,600.00	30,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,572,933.53	-30,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,024,420.66	108,370,222.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-105,168,671.02	-80,794,254.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,581,038.00	24,079,310.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,390,666.46	-14,655,739.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,907,003.00	22,125,154.23
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,594,336.44	-9,054,000.08
393	Биет бус хөрөнгө	13,930,000.00	13,930,000.00
39301	Програм хангамж	1,070,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,070,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,930,000.00	13,930,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>311,363,803.18</u>	<u>344,435,093.22</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>311,363,803.18</u>	<u>344,435,093.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	311,363,803.18	344,435,093.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	209,622,987.00	209,622,987.00
51101	Өмч: - төрийн	209,622,987.00	209,622,987.00
512	Хуримтлагдсан үр дүн	-58,821,539.17	-25,479,249.13
51210	Өмнөх үеийн үр дүн	-58,821,539.17	-58,550,539.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	33,071,290.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,562,355.35	160,291,355.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>311,363,803.18</u>	<u>344,435,093.22</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	466,747,746.00	676,842,042.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	371,307,949.00	493,413,752.59
120	Нийтлэг татварын бус орлого	27,722,649.00	120,271,352.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,722,649.00	120,271,352.59
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	27,722,649.00	120,271,352.59
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	343,585,300.00	373,142,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	343,585,300.00	373,142,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	95,439,797.00	183,428,290.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,160,657.00	106,447,190.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,302,319.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,652,438.00	104,750,790.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	205,900.00	1,696,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,627,600.00	47,335,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,627,600.00	47,335,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,651,540.00	29,645,300.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,651,540.00	29,645,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	456,622,802.46	643,770,752.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	439,848,283.85	616,020,752.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	439,848,283.85	616,020,752.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,175,581.35	311,260,013.95
210101	Үндсэн цалин	163,981,285.28	188,677,070.92
210102	Нэмэгдэл	72,705,497.60	100,011,025.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,364,990.00
210104	Урамшуулал	18,488,798.47	18,206,927.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,422,729.37	41,359,530.89
210201	Тэтгэврийн даатгал	22,267,159.49	28,834,253.41
210202	Тэтгэмжийн даатгал	2,619,663.24	3,238,600.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,058,771.01	2,496,800.22
210204	Ажилгүйдлийн даатгал	497,919.86	617,261.48
210205	Эрүүл мэндийн даатгал	4,979,215.77	6,172,615.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,736,622.67	43,396,300.00
210301	Гэрэл, цахилгаан	4,235,952.67	4,132,580.49
210302	Түлш, халаалт	37,507,470.00	37,270,519.51
210303	Цэвэр, бохир ус	1,993,200.00	1,993,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,856,116.00	24,528,158.00
210401	Бичиг хэрэг	1,632,870.00	3,702,530.00
210402	Тээвэр, шатахуун	11,627,991.00	15,476,428.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,700,000.00	2,310,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,808,500.00	2,164,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,086,755.00	875,000.00
2105	Нормативт зардал	34,786,861.38	144,295,375.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,130,066.38	134,025,403.50
210502	Хоол, хүнс	5,394,295.00	9,769,971.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,262,500.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,662,593.00	4,339,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,767,593.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	475,000.00	400,000.00

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	4,420,000.00	3,939,500.00
2107	Томилолт, зочны зардал	878,000.00	376,000.00
210702	Дотоод албан томилолт	878,000.00	376,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,182,094.00	12,695,940.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,882,094.00	12,695,940.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,147,686.08	33,769,934.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,978,420.00	3,755,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,169,266.08	30,014,634.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,774,518.61	27,750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,034,100.00	27,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,034,100.00	27,750,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,739,441.28	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,739,441.28	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	977.33	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	977.33	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>10,124,943.54</u>	<u>33,071,290.04</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	195,692,987.00	134,191,054.02	-100,778,592.66	00.00	229,105,448.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	195,692,987.00	134,191,054.02	-100,778,592.66	00.00	229,105,448.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-15,762,877.89	00.00	-15,762,877.89
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,622,987.00	160,562,355.35	-58,821,539.17	00.00	311,363,803.18
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,622,987.00	160,562,355.35	-58,821,539.17	00.00	311,363,803.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	271,000.00	00.00	271,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	209,622,987.00	160,562,355.35	-58,550,539.17	00.00	311,634,803.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-271,000.00	00.00	00.00	-271,000.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валлогын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	33,071,290.04	00.00	33,071,290.04
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,622,987.00	160,291,355.35	-25,479,249.13	00.00	344,435,093.22

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>439,025,097.00</u>	<u>539,108,890.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	343,585,300.00	373,142,400.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	343,585,300.00	373,142,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	343,585,300.00	373,142,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	95,439,797.00	165,966,490.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,160,657.00	106,447,190.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,302,319.00	00.00

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,652,438.00	104,750,790.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	205,900.00	1,696,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,627,600.00	47,335,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,627,600.00	47,335,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,651,540.00	12,183,500.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,651,540.00	12,183,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>433,725,097.00</u>	<u>538,576,972.84</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	433,725,097.00	538,576,972.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,950,578.39	510,826,972.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,175,581.35	311,260,013.95
210101	Үндсэн цалин	163,981,285.28	188,677,070.92
210102	Нэмэгдэл	72,705,497.60	100,011,025.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,364,990.00
210104	Урамшуулал	18,488,798.47	18,206,927.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,422,729.37	41,359,530.89
210201	Тэтгэврийн даатгал	22,267,159.49	28,834,253.41
210202	Тэтгэмжийн даатгал	2,619,663.24	3,238,600.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,058,771.01	2,496,800.22
210204	Ажилгүйдлийн даатгал	497,919.86	617,261.48
210205	Эрүүл мэндийн даатгал	4,979,215.77	6,172,615.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,736,622.67	43,396,300.00
210301	Гэрэл, цахилгаан	4,235,952.67	4,132,580.49
210302	Түлш, халаалт	37,507,470.00	37,270,519.51
210303	Цэвэр, бохир ус	1,993,200.00	1,993,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,502,291.00	22,158,628.00
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,772,200.00
210402	Тээвэр, шатахуун	11,627,991.00	15,476,428.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,700,000.00	2,310,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,750,000.00	1,600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,924,300.00	00.00
2105	Нормативт зардал	39,468,220.00	81,321,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,382,557.00	72,854,400.00
210502	Хоол, хүнс	4,085,663.00	7,967,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,090,000.00	4,339,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	400,000.00
210604	Урсгал засвар	3,890,000.00	3,939,500.00
2107	Томилолт, зочны зардал	878,000.00	376,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,745,834.00	615,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,445,834.00	615,100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,931,300.00	6,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,931,300.00	6,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,774,518.61	27,750,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,034,100.00	27,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,034,100.00	27,750,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,739,441.28	00.00

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,739,441.28	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	977.33	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	977.33	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,300,000.00</u>	<u>531,917.16</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,300,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,300,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,300,000.00	00.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	5,300,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,300,000.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	531,917.16
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	531,917.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	446,945,200.00	432,657,782.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	446,945,200.00	432,657,782.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	443,945,200.00	429,657,782.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,825,300.00	276,709,422.95
210101	Үндсэн цалин	170,614,200.00	176,071,940.92
210102	Нэмэгдэл	84,294,800.00	78,065,564.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,796,000.00	4,364,990.00
210104	Урамшуулал	24,120,300.00	18,206,927.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,801,400.00	36,486,531.89
210201	Тэтгэврийн даатгал	28,008,300.00	25,520,614.41
210202	Тэтгэмжийн даатгал	2,948,300.00	2,848,760.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,358,600.00	2,184,928.22
210204	Ажилгүйдлийн даатгал	589,700.00	539,293.48
210205	Эрүүл мэндийн даатгал	5,896,500.00	5,392,935.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,396,300.00	43,396,300.00
210301	Гэрэл, цахилгаан	3,900,000.00	4,132,580.49
210302	Түлш, халаалт	37,502,900.00	37,270,519.51
210303	Цэвэр, бохир ус	1,993,400.00	1,993,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,735,000.00	22,087,228.00
210401	Бичиг хэрэг	3,500,000.00	2,772,200.00
210402	Тээвэр, шатахуун	15,935,000.00	15,405,028.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,700,000.00	2,310,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,600,000.00	1,600,000.00
2105	Нормативт зардал	39,647,700.00	39,647,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,947,700.00	34,947,700.00
210502	Хоол, хүнс	4,200,000.00	4,200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,339,500.00	4,339,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	400,000.00	400,000.00
210604	Урсгал засвар	3,939,500.00	3,939,500.00
2107	Томилолт, зочны зардал	800,000.00	376,000.00

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	800,000.00	376,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,400,000.00	615,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,400,000.00	615,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6000000.00	6000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	6,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3000000.00	3000000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	3,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	3,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	446,945,200.00	432,661,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	373,142,400.00	373,142,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	373,142,400.00	373,142,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,335,800.00	47,335,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	47,335,800.00	47,335,800.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,467,000.00	12,183,500.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	26,467,000.00	12,183,500.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	105,919,190.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	105,919,190.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,169,190.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,550,591.00
210101	Үндсэн цалин	12,605,130.00
210102	Нэмэгдэл	21,945,461.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,872,999.00
210201	Тэтгэврийн даатгал	3,313,639.00
210202	Тэтгэмжийн даатгал	389,840.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	311,872.00
210204	Ажилгүйдлийн даатгал	77,968.00
210205	Эрүүл мэндийн даатгал	779,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	71,400.00
210402	Тээвэр, шатахуун	71,400.00
2105	Нормативт зардал	41,674,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,906,700.00
210502	Хоол, хүнс	3,767,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24750000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,750,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	106447190.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	106,447,190.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,750,790.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,696,400.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төв нь “Хүн амд эмнэлгийн тусламжийг жигд хүртээмжтэй, чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг эрхэмлэнэ” гэсэн зорилгын хүрээнд мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж, тэдний ололт амжилтаар дамжуулан дэвшилтэт технологи, техник төхөөрөмжийг эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлж, бүсийн сум дундын эмнэлэг болох зорилт дэвшүүлэн үйл ажиллагаандаа 643.7 сая төгрөгийг зарцуулан ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвд тайлант хугацаанд Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрын хамтарсан шалгалтын бүрэлдэхүүн ковид-19 цар тахалтай холбоотой шалгалт хийж, мэргэжил арга зүйгээр зөвлөн тусалжээ. Мөн Санхүүгийн

хяналт аудитын албаны төлөвлөгөөт шалгалтыг 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдэж зөрчил илрээгүй бөгөөд малын үнийг зах зээлийн үнээр данс бүртгэлд тусгах зөвлөмж өгчээ

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 456.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.8 сая, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 4.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33.1 сая төгрөг буюу 10.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71.4	112.7	41.3
Мөнгөн хөрөнгө	0	0.5	0.5
Төрийн сангийн харилцах	0	0.03	0.03
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0	0.5	0.5

Авлага	0	17.4	17.4
Бусад авлага	0	17.4	17.4
Бараа материал	71.4	94.7	23.3
Үндсэн хөрөнгө	239.9	231.7	-8.2
Нийт хөрөнгө	311.3	344.4	33.1
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	311.3	344.4	33.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	311.3	344.4	33.1

Бараа материалын дансны үлдэгдэл 94.7 сая төгрөг болж 23.3 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал 0.1 сая, бусад хангамжийн материал 3.1 сая, мал амьтад үнийн зөрүүнээс 24.7 сая, нийт 27.9 сая төгрөгөөр үлдэгдэл өссөн, тусгай зориулалтын материал 1.7 сая, бичиг хэргийн материал 1.0 сая, нийт 2.7 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 398.6 сая төгрөг болж 22.2 сая төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн газраас эмнэлгийн зориулалттай тоног төхөөрөмж 24.5 сая, бусад хөрөнгө 0.4 сая, нийт 24.9 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн бөгөөд нийт 24.9 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 69 дугаар тогтоолоор 4.9 сая төгрөгийн 4 ширхэг мотоциклийг, Аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 64 тоот албан бичгээр 146 нэр төрлийн 42.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасагдаж, 30.1 сая төгрөгийн элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 17.4 сая төгрөг болж өссөн нь Эрүүл мэндийн сайдын А/337-99 тоот тушаалын дагуу ковид-19 цар тахлаар өвчлөн хэвтэн эмчлүүлсэн иргэний төлбөр эрүүл мэндийн даатгалаас олгоогүйтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 344.4 сая төгрөг болж 33.1 сая төгрөгөөр өссөн байна.

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 210.1 сая төгрөгөөр буюу 45.0 хувиар өссөн нь улсын төсвөөс санхүүжих 29.5 сая, ЭМД-ийн санхүүжилт 7.9 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 95.0 сая, туслах үйл ажиллагааны орлого 1.6 сая, нийт 96.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, мөн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 92.5 сая төгрөгөөр нэмэгджээ. Орон нутгийн дээд шатны төсөв захирагчаас санхүүжих 16.3 сая, орон нутгийн санхүүжилт 0.3 сая, төгрөгөөр буурсан тус тус нөлөөлжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, дээд шатын төсөв захирагчаас үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 187.1 сая төгрөг буюу 40.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь ковид-19 цар тахалтай холбоотой цалин, НДШ, эмийн зардал, ариутгал халдваржуултал, тээвэр шатахуун, нэг удаагийн тэтгэмжийн зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 481.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 34.9 сая төгрөгөөр бууруулж, 446.7 сая төгрөгөөр баталсан.

Төсвийн төлөвлөлтөд дүн шинжилгээ хийхэд 2021 онд батлагдсан орон тоог бүрэн ажиллахаар үр дүнгийн урамшууллыг 60 хувиар тооцож, нэмэгдүүлсэн боловч 2021 оны төсвийг 466.7 сая төгрөг баталж, 34.9 сая төгрөгөөр бууруулсан байна. Тухайн төсвийн төслийг ТЕЗ-ын төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх шаардлага байна. Цаашид хөрөнгө оруулалтын зардал, орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой зардал болон бусад зардлуудыг төлөвлөхөд ТЕЗ-ын төсвийн хүрээнд мэдэгдлийг баримтлах, түүнтэй уялдуулан боловсруулах шаардлагатай байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг улсын төсвөөс 373.1 сая, орон нутгийн төсвөөс 47.3 сая, эрүү мэндийн даатгалаас 26.4 сая, нийт 446.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 432.6 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ковид-19 цар тахалтай холбоотой хэвтэн эмчлүүлэгчийн ор хоногийн санхүүжилт, дархлаажуулалт вакцины санхүүжилт, эмнэлгийн албан хаагч нарт нэг удаагийн тэтгэмжид 104.7 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 1.6 сая, нийт 106.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс 34.5 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл 4.8 сая, Ковид-19 цар тахалтай холбоотой эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, тээвэр шатахуун, хоол хүнс 41.9 сая, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 24.7 сая, нийт 105.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд сумын засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж, 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд зориулан төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 96.3 хувийн биелэлттэй байна. Төсвийн шууд захирагч 3 удаа солигдсоноос шалтгаалж гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт дүгнэгдээгүй байна.

Сумын Засаг даргын 2021 оны А/58 тоот захирамжаар нөөц сангийн зардлаас 20.3 сая төгрөгийн түргэвчилсэн шинжилгээний оношлуур худалдан авч иргэдэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлжээ.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал ажиглагдаагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа болоогүй мэдээлэл 2, хугацаа хоцроосон мэдээлэл 1, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага 562.0 сая төгрөгийн 29 мэдээлэл шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг үүсээгүй .

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 64 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага 562.0 сая төгрөгийн 29 мэдээлэл шилэн дансны цахим хуудсанд хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулгын “нийцсэн бөгөөд зохистой” байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

1	Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төв	2	-	-	-	-	-	-	-	2	-
---	-----------------------------------	---	---	---	---	---	---	---	---	---	---